

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго, хамрах хүрээ

Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутагт байрлах Хай Би Ойл ХК-ийн Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн БОННУ-ний ажлын явцад хот тохижилтын үйл ажиллагааны товч танилцуулга, эрхлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны тодорхойлолт болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн суурь төлөв байдлыг тодруулж барилгажилт болон үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд тэдгээрийн цар хүрээг тооцон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээний зөвлөмжийн хүрээнд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсрууллаа.

Байгаль орчны менежментийн зорилго: Төслийн барилгын үе шат болон үйл ажиллагаанаас байгаль орчин болон хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлж урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах болон ургамал, хөрс, ус, агаарыг чанарын өөрчлөлтийг хянах үйл ажиллагаа бодитой төлөвлөх нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго оршино.

Гол зорилтууд:

Нарийвчилсан үнэлгээнд тодорхойлогдож үнэлэгдсэн гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний байгаль хамгаалах төлөвлөгөө боловсруулах

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулах

Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөх

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тайлагнах, хэлэлцүүлэх хувиар төлөвлөх

Төслийн ерөнхий үнэлгээний нөхцөлд заагдсаны дагуу байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэхээр зорьж буй арга хэмжээний талаар жил бүрийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж БОАЖЯ-д ирүүлэн батлуулах ба батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг холбогдох газруудад хүргүүлж байх шаардлагатай.

Үүнээс гадна тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан “БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь”-ийн дагуу оролцогч сонирхогч талуудыг холбогдох мэдээллээр ханган ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгч хүлээнэ.

Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр хэрэгжих явцад биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө, түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагагүй юм.

Хүснэгт 1. Байгаль орчны менежментийн төлөвлгөөний зардал

№	Зардлын утга	Зардал, мян.төг
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	1,300,000
2	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	1,000,000
3	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	3,600,000
4	Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	1,000,000
5	Ажилчдын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	3,000,000
6	Осол, эрсдлийн менежментийн зардал	1,000,000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1,740,000
8	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	3,000,000
9	Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэгийн зардал	300,000
10	Хог хаягдлын менежмент	2,000,000
11	Ногоон байгууламж байгуулах зардал	1,215,000
Нийт зардал		19,155,000

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоож үнэлсэн. Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нарийвчлан тогтоов.

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл	Санал болгож буй урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, Зардал, мян.төг	Харнуцах	Хяналт явуулах байгууллага	Хяналтын шалгуур
				2026 он			
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах							
1	Төслийн үйл ажиллагаа	Төслийн түүхий эд ашигласан хаягдал тос болон бэлэн болсон бүтээгдэхүүн тээвэрлэх, явцад тоосжилт үүсэж агаарын чанарыг бага хэмжээгээр доройтуулна	Шаардлагагүй машин, техник хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах; Ил задгай хог хаяхгүй байх анхааруулга, санамж бүхий самбар тэмдэгжүүлэлтийг хийх;	100.0	Төсөл хэрэгжүүлэгч	Хай Би Ойл ХК,	Агаарын бохирдлыг бууруулахаар хийгдсэн арга хэмжээ
2			Ажлын байранд агаарын чанарын хяналтыг явуулж ажилчид өртөж байгаа нь багажийн хэмжилтээр тогтоогдсон тохиолдолд агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нэмж төлөвлөх	Үйл ажиллагааны зардлаар		Итгэмжлэгдсэн лаборатори, байгууллага	MNS4990:2000, MNS 4585:2016
3			Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах. Төслийн талбайд 3 сар тутамд агаарын чанарын хяналт хийнэ. Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаарт ялгарах хий дэх бохирдуулагч бодисын хэмжээ нь стандартаар зөвшөөрөгдсөн	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан	Төсөл хэрэгжүүлэгч	Итгэмжлэгдсэн лаборатори, байгууллага	MNS4990:2000, MNS 4585:2016

			хэмжээнээс хэтрэхгүй байна.				
4	Нефт бүтээгдэхүүн	Агаарын чанарыг доройтуулна а	Агаар орчинд нефт бүтээгдэхүүн ууршилт дээр хяналт тавих, мониторинг хийх. Нефт бүтээгдэхүүн ил задгай алдагдахаас сэргийлэх	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч	Хай Би Ойл ХК,	Агаарын бохирдлыг бууруулахаар хийгдсэн арга хэмжээ
	Төслийн үйл ажиллагаа	Ашигласан хаягдал тос хүрээлэн буй орчны агаарын чанарт нүлүүлэх	Ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн хэвийн ажиллагааг хангах	600.0	Төсөл хэрэгжүүлэгч		Агаарын тухай хууль, MNS 4585:2016
			Ашигласан хаягдал тосыг тээвэрлэх, дахин Боловсруулахдаа техник, тоног Төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах	600.0	Төсөл хэрэгжүүлэгч		Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
	Төслийн үйл ажиллагаа	үйлдвэрийн ажилчид шуугианы бохирдолд үртэх	- Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардалд тусгагдсан	Төсөл хэрэгжүүлэгч		Ажлын байрны агаарын эрөөл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998
			- Хөдөлмөр хамгааллын хэрэгслийн ашиглалтад хяналт тавих	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардалд тусгагдсан	Төсөл хэрэгжүүлэгч		(хөн ам суурьшсан хэсгөөд) MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрөөл ахуй. Шуугианы аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага

								MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, төвшний хэмжээ
Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах								
5	Машин, механиз мын ашиглалт	Хөрсний бохирдол явагдана	Техникийн ашигласан тос цуглуулах цэгүүдээс төсөл хэрэгжих талбай хүртэлх замыг засаж сайжруулах, тоосжилт ихтэй үед тоос дарах арга хэмжээ авч ажиллах. Барилга байгууламж болон зам талбайд урсгал засвар хийх.	1300.0	Төсөл хэрэгжү үлэгч	Хай Би Ойл ХК,	Хөрс хамгаалах талаар хийгдсэн ажлууд	
6			Төслийн талбайгаас авсан хөрсний дээжид хүнд металлын бохирдол хэдий илрээгүй ч цаашид тогтмол “Хөрс бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2019 стандартад заасан хүлцэх хэмжээнд байгаа эсэхийг байнга хянаж дотоод мониторинг хийж байх, бохирдол илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагамэргэжилтэн судлаачдаас зөвлөмж авч багасгах, бууруулах арга хэмжээ авах;	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан	Төсөл хэрэгжү үлэгч	Хай Би Ойл ХК	Хөрс хамгаалах талаар хийгдсэн ажлууд	
7	Үйлдвэри йн үйл ажиллаг	Газрын хэвлий болон хөрсөн бүрхэвчид	Техникийн үзлэг үйлчилгээ, хяналтын тохиргоо, ашиглалтын үеийн ачаалал,	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжү үлэгч	Хай Би Ойл ХК, Байгаль	Хөрс хамгаалах талаар хийгдсэн ажлууд	

	aa	сөрөг нөлөөлөл үзүүлнэ.	цахилгаан хэлбэлзэл, газардуулгын системийн хяналтыг холбогдох Мэргэжлийн байгууллагаар хянан баталгаажуулж байх Байгууламж нь цэвэр, бохир усны системтэй, цахилгааны төвийн эх үүсвэртэй, үерийн далан, сувагтай, бохир ус цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах.			орчны хэрэгжилтийн тайлан	
8	Үйлдвэрийн үйл ажиллагаа	Газрын хэвлий болон хөрсөн бүрхэвчид сөрөг нөлөөлөл үзүүлнэ.	Нефт бүтээгдэхүүний ил болон далд агуулах нь нефт бүтээгдэхүүний шүүрлээс хөрс, газрын доорх болон гадаргын усбохирдохоос хамгаалах Зориулалттай доторлогооны систем, шүүрэл цуглуулах, зайлуулах системтэй байх бөгөөд төслийн бүх үе шатанд хэвийн ажиллагааг хангаж ажиллах.	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжүүлэгч	Хай Би Ойл ХК, Байгаль орчны хэрэгжилтийн тайлан	Хөрс хамгаалах талаар хийгдсэн ажлууд
9	Төслийн үйл ажиллагаа	Хөрсөн бүрхэвчийг доройтуулна	Тэжээвэр амьтан, гадны хүн орохооргүй хашаа хамгаалалттай, байнгын харуултай, гадна талдаа хаяг, био-аюулгүйн таних тэмдэг байрлуулсан байх ба эдэлбэр газрын 30%-аас доошгүй газарт ногоон байгууламжтай байна.	2300.0	Төсөл хэрэгжүүлэгч	Хай Би Ойл ХК, Байгаль орчны хэрэгжилтийн тайлан	Хөрс хамгаалах талаар хийгдсэн ажлууд
10	Төслийн	Хөрсний	Ашигласан хаягдал тос, нефт	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл	Хай Би	Хөрс хамгаалах

үйл ажиллаг аа	бохирдол явагдана	Бүтээгдэхүүнтэй ажиллах заавар зөвлөгөө, ашигласан хаягдал тос хүрээлэн буй орчинд алдагдсан тохиолдолд авах хариу арга хэмжээний хөтөлбөр боловсруулж ажиллах		хэрэгжү үлэгч	Ойл ХК	талаар хийгдсэн ажлууд	
Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах							
11	Усны нөөцийн ашиглал т	Усны нөөцийн хомсдол	Байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэх нөхцөлийг хязгаарлах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх үүднээс усны чанарын байдалд байнгын хяналт, мониторингийг дотооддоо болон гаднын байгууллагаар хийлгүүлэх	1000.0	Төсөл хэрэгжү үлэгч	-	
8			Технологийн хэрэглээний явцад гарах хаягдал усыг эргүүлэн ашиглана. Үйл ажиллагааны онцлог хүчин чадалд тохирсон цэвэрлэх байгууламж байгуулах			Хай Би Ойл ХК БОУАӨЯ-МХГ	Бохир усыг цэвэршүүлэх ажиллагаа, MNS-4943:2015
9			Унд ахуйн хэрэглээний усыг хангаж буй гүний худгийн тоолуурын бүрэн бүтэн байдлыг хангах, тоолуурын заалтыг үндэслэн ашигласан усны төлбөрийг барагдуулах	Үйл ажиллагааны зардлаар		Хай Би Ойл ХК БОУАӨЯ-МХГ	-
10			Ахуйн шингэн хаягдал хуримтлуулах цооногт хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллах	Үйл ажиллагааны зардлаар		Хай Би Ойл ХК БОУАӨЯ-МХГ	-

11			Ус хангамжийн худгийн усны түвшний бууралт, горим, чанарын өөрчлөлтийг байнга хянах зорилгоор усны чанарын шинжилгээг хийж үр дүнг хянаж ажиллах	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан		Хай Би Ойл ХК БОУАӨЯ-МХГ	MNS (ISO) 5667-5:2001- усны чанар-дээжлэлт
Ургамалан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах							
12	Төслийн үйл ажиллаг аа	Ургамлан нөмрөг талхлагдана	Ил хөрстэй болон эвдрэлд орсон талбайг нөхөн сэргээж ургамалжуулах замаар гадаргаас сул тоос, шороо хийсэх нөхцөлийг бууруулах, шаардлагагүй шороон зам үүсэхээс сэргийлэх, тэмдэгжүүлэх, мэргэжлийн байгууллага, хүмүүсийн оролцоотойгоор ногоон байгууламж байгуулж, тогтмол арчилж байх	1000.0	Төсөл хэрэгжү үлэгч	Газрын алба, БОГ	Байгаль хамгаалах ажил
13			Ногоон байгууламжид ашиглах нутгийн ургамлын үрийн нөөц бүрдүүлэх, тарьж ургуулах, харь зүйлийн ургамлын үр, суулгац суулгахаас татгалзах	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээнд тусгагдсан			ТХ
Нутгийн оршин суугчид, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах							
16	Төслийн үйл ажиллаг аа	Мэдээллийн хангалтгүй байдал	Дүүрэг, хорооны удирдлагуудад өөрийн үйл ажиллагааны талаар жил бүр танилцуулга хийх,	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжү үлэгч	Дүүрэг, хорооны засаг захиргаа	-
17		Ажлын байрны хангамж	Ажлын байраар орон нутгийн иргэдийг хангах,	Үйл ажиллагааны зардлаар			Төсөл хэрэгжү

					үлэгч	засаг захиргаа, БОГ	
18		Ажилчдын эрүүл мэнд	Бүх ажилтнууд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон хугацаат үзлэгийн журамд заасан үзлэг шинжилгээнд хамрагдахаас гадна В вирус т хепатат, татрангийн эсрэг дархлаажуулалтад заавал хамруулах, ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр хангах	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжү үлэгч		-
19	Төслийн үйл ажиллаг аа	Ажилчдын эрүүл мэнд	Бүх ажилтнууд нь сертификат бүхий хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн холбогдох сургалтуудад хамрагдсан байна.	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжү үлэгч	Онцгой байдлын газар	Дадлага эзэмшүүлэх сургалт явуулсан ажлын протокол
20			Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг шаардлагын дагуу авч хэрэгжүүлэх Галын аюулгүй байдлыг хангах, дотоод дүрмийг сахих, гал унтраах тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай байлгах, тэдгээрийг нийт ажиллагсдад ашиглуулж сургах, сургалт зохион байгуулах	1000.0	Төсөл хэрэгжү үлэгч	Онцгой байдлын газар	Дадлага эзэмшүүлэх сургалт явуулсан ажлын протокол

21	Төслийн үйл ажиллаг аа	Ажилчдын эрүүл мэнд	Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэж болох аюул, ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулах Аюулгүй ажиллагааны заавар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, зааврыг нүдэнд ил харагдахуйц том, тод бичиж хананд байрлуулах	500.0	Төсөл хэрэгжү үлэгч	Онцгой байдлын газар	Болзошгүй аюул ослоос хамгаалах ажил
22	Төслийн үйл ажиллаг аа	Ажилчдын эрүүл мэнд	Нефт бүтээгдэхүүн хүрээлэн буй орчинд алдагдахаас сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй байна. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч газрын доорх ус, гадаргын ус, хөрс, агаарын хяналт-шинжилгээний болон хариу арга хэмжээний хөтөлбөртэй байна	1000.0	Төсөл хэрэгжү үлэгч	Онцгой байдлын газар	Болзошгүй аюул ослоос хамгаалах ажил
23	Төслийн үйл ажиллаг аа	Ажилчдын эрүүл мэнд	Нефт бүтээгдэхүүн хүрээлэн буй орчинд алдагдахаас сэргийлэх, шатах тослох материал байгуулах, үйл ажиллагаа явуулах, засвар үйлчилгээ хийх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах	500.0	Төсөл хэрэгжү үлэгч	Онцгой байдлын газар	Болзошгүй аюул ослоос хамгаалах ажил

			шаардлагатай.				
24	Төслийн үйл ажиллаг аа	Ажилчдын эрүүл мэнд	Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаа гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж батлуулж, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжү үлэгч	, Онцгой байдлын газар	Болзошгүй аюул ослоос хамгаалах ажил
25	Төслийн үйл ажиллаг аа	Ажилчдын эрүүл мэнд	Нийт ажилчдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, хог хаягдлын менежментийн сургалтад хамруулах. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын 2011 оны 08 дугаар захирамжаар баталсан хүн нэг бүрийн анхан шатны тусламжийн үүргэвчинд байвал зохих зүйлсийн жагсаалтын дагуу бэлтгэж, бэлэн байдлыг хангуулах	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжү үлэгч	Онцгой байдлын газар	Дадлага эзэмшүүлэх сургалт явуулсан ажлын протокол
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН				7900.0			

2. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах гол арга зам бол осол, эрсдлийг гаргахгүй байх юм. Иймээс байгууламж нь 2023 онд аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар төлөвлөсөн. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, өглөө бүр ХААБ сургалтыг хийхээр төлөвлөсөн. Мөн авто ослоос сэргийлэн анхааруулах тэмдэг тэмдэглэгээ 10 ш байрлуулахаар төлөвлөсөн. Төслийн дэд бүтэц, барилга байгууламж, ногоон байгууламжаас бусад хэсгийг бүрэн цементжүүлэх, асгаралтын журам боловсруулж мөрдөж ажиллахаар төлөвлөсөн. Эдгээр ажлын зардалд 5 575 000 төгрөг зарцуулах бөгөөд ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр хангах болон эмнэлгийн үзлэгийн зардлыг үйл ажиллагааны зардалд тусгахаар төлөвлөсөн.

Хүснэгт 3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, Зардал, мян.төг	Хяналт явуулах байгууллага	Баримтлах эрх зүйн баримт бичиг
					2026 он		
2	Ажилчид гэмтэж бэртэх	Ажилчдыг хөдөлмөр хамгаалалтын хэрэгслээр хангаж ажиллах	Бүх ажилчид		Үйл ажиллагааны зардалд орно.	Хай Би Ойл ХК	
3	Гал түймэр гарах	Гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материал, хувийн хамгаалах хэрэгслийг шаардлагатай газар байрлуулж, солиж цэнэглэж ашиглалтын бэлэн байдлыг хангасан байх		Иж бүрэн	700.0	Хай Би Ойл ХК	Галаас хамгаалах тухай хууль

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, Зардал, мян.төг	Хяналт явуулах байгууллага	Баримтлах эрх зүйн баримт бичиг
					2026 он		
4	Ажилчдын хайхрамжгүй үйлдлээс болж осол гарах	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт явуулах	Бүх ажилчид	Өдөр бүр	300.0	Хай Би Ойл ХК	ХААБ зааварчилгаа
5	шаардлагатай газруудад мэдээллийг нүдэнд харагдахуйц газар байрлуулсан байна	гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материалын байрлалыг заасан зураг, схем; аюултай хог хаягдал хариуцсан ажилтны овог нэр, утасны дугаартай самбар	Төслийн талбайд	10	200.0	Хай Би Ойл ХК	
6	Эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа		5 хүн.	1000.0	Эрүүл мэндийн байгууллага	

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, Зардал, мян.төг	Хяналт явуулах байгууллага	Баримтлах эрх зүйн баримт бичиг
					2026 он		
		эрхлэгч нь ажилтнуудыг жилд нэг удаа эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.					
7	Аюул устгах төлөвлөгөө боловсруулж батлуулж мөрдөж ажиллах	Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулах хэмжээгээр агаар, хөрс, усанд санамсаргүй болон санаатайгаар аюултай хог хаягдал алдах, тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах үед үүсэх эрсдэлийг			-	Онцгой байдлын газар	

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, Зардал, мян.төг	Хяналт явуулах байгууллага	Баримтлах эрх зүйн баримт бичиг
					2026 он		
		Хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулах зорилго бүхий аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөтэй байна.					
	Нийт				1200.0		

3. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутагт хэрэгжиж буй Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон түүний үйл ажиллагааны явцад гарч болзошгүй эрсдэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох зорилготой заавал хэрэгжүүлэх баримт бичиг юм.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж үр дүнг нь доорхи асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Үүнд:

- Анх таамагласан сөрөг нөлөөллүүдийн хэмжээ, үр дагавраас бодит сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар хир зөрж байгааг
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, дүрэм журамтай нийцэж байгаа эсэхийг
- Нөлөөллүүдийн эрчим, буурах эсвэл ихэсч байгаа
- Төслийн БОМТ-ний нийт үр ашгийг үнэлэх зэрэг орно.

Хүснэгт4. Хяналт-шинжилгээ хийх

<p>7.1. Аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч газрын доорх ус, гадаргын ус, хөрс, агаарын хяналт-шинжилгээний болон хариу арга хэмжээний хөтөлбөртэй байх бөгөөд хөтөлбөрийн дагуу хяналт-шинжилгээг хийнэ.</p>	<p>7.2.1.хяналт-шинжилгээний төрөл, хугацаа, талбай;</p> <p>7.2.2.хяналт-шинжилгээ хийх арга;</p> <p>7.2.3.хариу арга хэмжээ.</p>	
<p>7.3. Газрын доорх усны хяналт-шинжилгээний цооног нь газрын гадаргаас доош босоо чиглэлд газрын доорх усны дээд үе хүртэл үргэлжлэх бөгөөд байгууламжийн газрын доорх усны хяналт-шинжилгээний систем нь газрын доорх усны хамгийн дээд үеэс дээж авах боломж бүхий гүнд суурилагдсан, тогтоосон цэгт гаргасан, хангалттай тооны хяналтын худагтай байна.</p>		
<p>7.4. Газрын доорх усны хяналтын худгаас дээж авах бүртгээ газрын доорх усны түвшинг хэмжиж, бүртгэл хөдөлнө.</p>		
<p>7.5. Газрын доорх усны хяналт-шинжилгээний үргэлжлэх хугацаа нь тухайн байгууламжийн үйл ажиллагаа эхлүүлэх зөвшөөрөл авсан</p>		

<p>өдрөөс байгууламжийг хаах хүртэл байна.</p> <p>7.6. Газрын доорх усны цооног гаргах зөвшөөрлийг тухайн орчны газрын доорх усны суурь судалгаа, цооногийн гүний болон байршлын зураг төсөлд үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.</p>		
<p>7.7. Гүний худаг болон гадаргын усанд хяналт-шинжилгээ хийх талбай нь байгууламжийн хилээс 1500 метрийн радиус дотор байна.</p>		
<p>7.8. Аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь байгууламжийг хаасан тохиолдолд Хог хаягдлын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу хаалтын дараах хяналт-шинжилгээг хийнэ.</p>		
<p>7.9. Хаалтын дараах хяналт-шинжилгээг дор дурдсан чиглэлээр хийж, тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ:</p>	<p>7.9.1.байгууламжийн бүрэн бүтэн байдал;</p> <p>7.9.2.шүүрэл ялгарч буй эсэх;</p> <p>7.9.3.газрын доорх усны хяналт-шинжилгээ.</p>	
<p>7.10. Газрын доорх усны хяналт-шинжилгээг тухайн байгууламжийг хаасан өдрөөс хойш газрын доорх усны чанар дараалсан 3 жилийн турш стандартын шаардлага хангаж байгааг нь нотлогдсон тохиолдолд зогсооно.</p>		
<p>7.11. Аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч хяналт-шинжилгээгээр ялгарал, шүүрэл илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, нөлөөллийг арилгах арга хэмжээг авна.</p>		
<p>7.12. Аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч Хог хаягдлын тухай хуулийн 32.7-д заасан зардлыг итгэлцлийн сан байгуулж төвлөрүүлэх тохиолдолд дараах журмыг мөрдөнө:</p>	<p>7.12.1.нийт зардлыг тухайн байгууламжийн ажиллах жилд хувааж, нэг жилд ноогдох хэмжээг тогтооно;</p> <p>7.12.2.эхний жилд ноогдох зардлыг анхны хог хаягдлаа</p>	

	хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор, дараагийн жилүүдэд өмнөх жилийн зардал дансанд төвлөрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор тус тус итгэлцлийн санд төвлөрүүлнэ.	
7.13. Аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч Хог хаягдлын тухай хуулийн 32.7-д заасан зардлыг барьцаа хөрөнгө байршуулах замаар төвлөрүүлэх тохиолдолд нийт зардлыг анхны хог хаягдлаа хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор барьцаа хөрөнгийн дансанд байгууламжийг хаах хүртэлх хугацаагаар, зарцуулах эрхгүйгээр байршуулна.		
7.14. Энэ журмын 7.12, 7.13-т заасан дансанд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулахтай холбогдсон үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан гэрээгээр зохицуулна.		

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх, батлагдсан арга зүйг баримтлан стандартчилагдсан багаж, хэрэгслээр дээж, шинжилгээ хийх болон өгөгдлийг боловсруулах ажлыг Хай Би Ойл ХК-ийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтнууд удирдан явуулна. Мөн төслийн ажлыг удирдан явуулж буй компани, болон бусад гүйцэтгэгч, гэрээлэгч нар энэхүү ОХШХ-ийг үйл ажиллагаандаа баримтлах шаардлагатай.

Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
1. Агаарын чанар				
Агаарын бохирдлын цэгэн эх үүсвэр: TSP, SO _x , NOX, CO _x , PM	Үйлдвэрийн гадна, дотор талд, машин зам, зогсоол, агуулах орчмоос TSP, SO _x , NOX, CO _x , PM	Жилд 2 удаа	240.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерүнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерүнхий шаардлага, MNS 17.2.5.11 Агаар дахь хүхэрлэг хийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 17.2.5.12 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 5002:2000 Хүдүлмүрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерүнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшиний хэмжээ
Дуу шуугианы хэмжилт хийх	үйлдвэрийн байран дотор, Түслийн талбай болон орчны бүсэд машин механизм, тоног түүхүүрүмжийн орчим	Жилд 1 удаа	200 0	
2. Гадаргын болон газрын доорх ус				

-Хэрэглээний усны чанар: PH, TDS, нийт хатуулаг, ууссан хүчилтөрөгч, нефт агууламж Ca, Mg, Na, K, SO4, NO2, NO3, NH4, As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Cr, Fe, Ni, амт, үнэр, өнгө	Гүний худаг	Жилд 2 удаа	180.0	Зарим онцлог дээжүүдийг авах, хадгалах, тээвэрлэх MNS (ISO) 5667-5:2001- усны чанар-дээжлэлт
3. Хөрсөн бүрхэвч				
-Хөрсний бохирдол, ялмагийн агууламж, хүнд металлын агууламж, нефт бүтээгдэхүүний шинжилгээ, эрүүл ахуйн шинжилгээ	үйлдвэрийн байран дотор, Түслийн талбай болон орчны бүсэд машин механизм, тоног түүхүүрүмжийн	Жилд 4 удаа	120.0	Дээжлэлт хийхэд MNS3297:1991 “Ариун цэврийн тухай” хууль: 7-р зүйл: 7.4, 7.5 MNS 3473:1983, MNS
4. Ургамлан нөмрөг				
Ургамлан нөмрөг, нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх	Ургамлын төрөл зүйлийн бүрдэл, хэтийн төлөв, ногоон байгууламжийн	Жилд 1 удаа	1000.0	Мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч ажиллах
Нэг жилийн зардал, мян.төг				1740.0

Зураг1. Орчны хяналт шинжилгээний зураг

